




Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн

2024 оны 10 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

10.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн  
бүтэц, орон тоо

1. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн бүтэц



2.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн орон тоо

№	Бүтэц	Орон тоо	Албан тушаал
1.	Шүүхийн сургалтын төв (15)	1	Шүүхийн академийн захирал
2.		1	Шүүхийн сургалтын төвийн дарга
3.		3	Дотоод сургалтын менежер
4.		2	Цахим сургалтын менежер
5.		1	Гадаад сургалтын менежер
6.		1	Сургалтын менежер
7.		1	Орчуулагч-гадаад харилцааны ажилтан
8.		1	Сургалтын хөтөлбөрийн хороо хариуцсан ажилтан
9.		5	Сургач багш
10.	Шүүхийн судалгааны төв (35)	1	Шүүхийн судалгааны төвийн дарга
11.		1	Эрүүгийн эрх зүйн секторын эрхлэгч
12.		1	Иргэний эрх зүйн секторын эрхлэгч
13.		1	Захиргааны эрх зүйн секторын эрхлэгч
14.		1	Үндсэн хуулийн болон олон улсын эрх зүйн секторын эрхлэгч
15.		7	Эрүүгийн эрх зүйн судлаач
16.		7	Иргэний эрх зүйн судлаач
17.		7	Захиргааны эрх зүйн судлаач
18.		7	Үндсэн хуулийн болон олон улсын эрх зүйн судлаач
19.		2	Бусад салбарын судлаач
20.	Мэдээллийн төв (10)	1	Мэдээллийн төвийн дарга
21.		1	Хэвлэл, олон нийттэй харилцах ахлах ажилтан
22.		2	Сэтгүүлч
23.		1	Эвлүүлэгч
24.		1	Студийн зураглаач
25.		1	Мэдээллийн технологийн ажилтан
26.		2	Шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэх ажилтан
27.	Үйлчилгээний алба (8)	1	Номын сангийн ажилтан
28.		1	Хүний нөөц, захиргааны ажилтан
29.		1	Санхүүгийн ажилтан-Нягтлан бодогч
30.		1	Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах ажилтан
31.		1	Санхүүгийн ажилтан-Нярав
32.		1	Архив, бичиг хэргийн ажилтан
33.		1	Жолооч
34.		2	Үйлчлэгч
Нийт		69	

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн  
2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн  
19 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН  
АКАДЕМИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан шүүгч бэлтгэх болон шүүгчийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, шүүн таслах ажиллагааг судалгаа, мэдээллээр хангах, Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Улсын дээд шүүхийн дэргэдэх байгууллага мөн.

1.2. Шүүхийн академи Монгол Улсын шүүхийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого болон холбогдох бусад хууль тогтоомж, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамж, Академийн ажиллах журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт заасны дагуу Шүүхийн академийн бүтэц, орон тоо, ажиллах журам, шүүгчийн сургалтын хөтөлбөрийг Улсын дээд шүүхийн танхимын саналыг харгалзан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч батална.

1.4. Шүүхийн академи чиг үүргээ бие даан гүйцэтгэх болон зохицуулан холбох аргаар хэрэгжүүлнэ.

1.5. Шүүхийн академи тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, бэлгэдэл, хэвлэмэл хуудас, харилцах данстай байна.

Хоёр. Шүүхийн академийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим

2.1. Шүүхийн академи сургалт, судалгаа, мэдээллийн байгууллагын нийтлэг үнэт зүйл, зарчмыг үйл ажиллагаандaa удирдлага болгон дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан шүүгч, шүүгчид нэр дэвшигчийн сургалт зохион байгуулах;

2.1.2. бүх шатны шүүхийн шүүн таслах ажлын практик, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг салбар эрх зүй, хэрэг, маргааны төрөл зэрэг чиглэлээр судалж, шүүх, шүүгчдийг судалгаа, мэдээллээр хангах;

2.1.3. Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргахад шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах;

2.1.4. шүүн таслах ажлын хууль хэрэглээний талаарх судалгаанд үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах;

2.1.5.шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;

2.1.6.онол, арга зүй, мэдээллийн улирал тутмын “Монголын төр, эрх зүй” сэтгүүл, Академийн үйл ажиллагааны цахим сонин эрхлэн гаргах;

2.1.7.сургалт, судалгаа, мэдээллийн бусад байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох;

2.1.8.олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээ, онол, практикийн бага хурал, сургалт, семинар зохион байгуулж хууль зүйн шинжлэх ухаан, шүүхийн хөгжилд дэмжлэг үзүүлэх;

2.1.9.Шүүхийн академийн төвүүд нь үйл ажиллагааны тайланг улирал, хагас жил, жилээр гаргаж, Шүүхийн академийн цахим мэдээллийн сурвалжид нийтлэх;

2.1.10.хууль тогтоомж, Шүүхийн академийн ажиллах журамд заасан бусад чиг үүрэг.

2.2.Шүүхийн академи энэ журмын 2.1-д заасан судалгааг суурь судалгааны арга зүйд тулгуурлан бие даан, эсхүл сонгон шалгаруулах зарчмаар бусдаар захиалан гүйцэтгүүлж болно. Шүүхийн академи бусад байгууллагын захиалгаар холбогдох судалгааг гүйцэтгэж болно.

2.3.Шүүхийн академи үйл ажиллагаандaa дараах зарчмыг баримтална:

2.3.1.хууль дээдлэх, шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг баримтлах;

2.3.2.судалгаатай, үндэслэлтэй хандах, хэрэгцээ, шаардлагад тулгуурлах;

2.3.3.судалгаа үр дүнтэй, чанартай байх;

2.3.4.сургалт тасралтгүй, хүртээмжтэй, онол, практик хосолсон, шинэ хандлагад нийцсэн байх;

2.3.5.холбогдох талуудын оролцоог хангах;

2.3.6.шинжлэх ухаан, судалгаа, сургалтын ёс зүйг сахин мөрдөх;

2.3.7.итгэл төрүүлэхүйц нэр хүндэд эрмэлзэх, хадгалах;

2.3.8.чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлэхдээ хариуцлагатай байх, хамтран ажиллах, харилцан туслах;

2.3.9.үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх;

2.3.10.шинжлэх ухаанч, бие даасан байх;

2.3.11.хууль тогтоомжид заасан бусад зарчим.

Гурав. Шүүхийн академийн удирдлага, зохион байгуулалт

3.1.Шүүхийн академийн удирдлага захирал, Сургалтын төв, Судалгааны төв, Мэдээллийн төвийн дарга нараас бүрдэнэ.

3.2. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5-д заасны дагуу Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Зөвлөгөөнд танилцуулснаар Академийн захирлыг томилж, чөлөөлнө. Академийн захирал дотоод, гадаадын үйл ажиллагаанд Академийг итгэмжлэлгүйгээр төлөөлж, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн өмнө ажлаа хариуцна.

3.3. Шүүхийн академийн захирал Сургалтын төв, Судалгааны төв, Мэдээллийн төвийн дарга, ажилтныг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулж, зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлнө. Төвийн дарга нар тухайн төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, Академийн захирлын өмнө ажлаа хариуцна.

3.4. Шүүхийн академийн захирал сургалт, судалгаа, мэдээллийн нэгдсэн бодлогыг хариуцан ажиллахын зэрэгцээ Академи, түүний нэгжүүдийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлд хяналт тавих, үр дүнг үнэлэх, дүгнэх, төвүүдийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, Академийн ажилтныг шагнаж урамшуулах, хариуцлага тооцох, байгууллагын дотоод журам болон албан тушаалын тодорхойлолт батлах, Шүүхийн академийн эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, энэ журамд нийцүүлэн дотоод журам, заавар, аргачлал батлах болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.5. Шүүхийн академийн удирдах, гүйцэтгэх албан тушаалд төрийн захиргааны, үйлчилгээний болон шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний орон тооны албан тушаал хамаарна.

3.6. Ажилтны эрх, үүргийг албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, байгууллагын дотоод журмаар нарийвчлан тодорхойлно.

3.7. Шүүхийн академи шүүхийн сургалт, судалгаанд зориулсан шүүхийн төрөлжсөн номын сантай байна. Номын сангийн ажиллах журмыг Шүүхийн академийн захирал батална.

3.8. Шүүхийн академи жил бүр үйл ажиллагааны тайлангаа нийт шүүгчдийн хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлнэ.

### Дөрөв. Шүүхийн Сургалтын төв

#### 4.1. Шүүхийн сургалтын төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1. шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хуулийг зөв хэрэглэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах мэргэшлийн хэрэгцээ, судалгаанд тулгуурласан сургалт зохион байгуулах;

4.1.2. шүүгчийн ёс зүй, ур чадвар болон хувь хүний чадавхыг хөгжүүлэх;

4.1.3. шүүгчид нэр дэвшигчийг бэлтгэх сургалт (цаашид “шүүгч бэлтгэх сургалт” гэх) зохион байгуулах;

4.1.4. Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх зорилгоор захиалгат сургалт зохион байгуулж болно.

4.2. Энэхүү журмын 4.1.1, 4.1.2-т заасан сургалт нь шүүгчийг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамаарна.

4.3. Энэхүү журмын 4.1.3-т заасан Шүүгч бэлтгэх сургалтыг Академийн захирлын баталсан хөтөлбөрийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулна.

4.4. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Академи сургалтын хөтөлбөр боловсруулах чиг үүрэг бүхий бүх шатны шүүхийн шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус хороотой байна. Тус хорооны ажиллах журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч батална.

4.5. Шүүхийн сургалтын төв нь Сургалтын хөтөлбөр боловсруулах хороотой хамтран ажиллаж, тус хорооноос гаргасан сургалтын нэгдсэн бодлогын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

4.6. Шүүхийн сургалтын төв нь Сургалтын хөтөлбөр боловсруулах хорооноос баталсан хөтөлбөрийн дагуу дараах төрлийн сургалт зохион байгуулна:

4.6.1. анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэн дадлагажуулах сургалт;

4.6.2. анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийг мэргэшүүлэх сургалт;

4.6.3. сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчийн заавал хамрагдах сургалт;

4.6.4. шүүгч-багш бэлтгэх сургалт;

4.6.5. сургагч багш бэлтгэх сургалт;

4.6.6. багц цаг хангах үргэлжилсэн сургалт;

4.6.7. хувь хүний хөгжил, манлайллын сургалт;

4.6.8. хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн бусад төрлийн сургалт.

4.7. Энэхүү журмын 4.6-д заасан сургалтад хамрагдсан шүүгчийн мэдээллийг Шүүхийн тухай хуулийн 24.4-т заасны дагуу холбогдох байгууллагад хүргүүлснээр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, багц цаг хангасанд тооцно.

4.8. Энэхүү журмын 4.1.4-т заасан захиалгат сургалтыг тодорхой шинэлэг сэдэв, хууль зүйн салбарын тулгамдсан бусад асуудлаар зохион байгуулж болно.

4.9. Сургалтын хэрэгцээ, онцлогт тулгуурлан гадаад болон дотоод сургалтыг танхим болон цахим /подкаст, контент, вебинар гэх мэт/ хэлбэрээр зохион байгуулна.

4.10. Сургалтын хөтөлбөр, арга зүйд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг, маргааны талаар тусгахгүй.

4.11. Шүүхийн сургалтыг улсын төсөв буюу Улсын дээд шүүхийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд Монгол Улсын олон улсын гэрээ, гадаад улсын шүүх, олон

улсын болон гадаад улсын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад гадаад улс болон олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр сургалтын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4.12.Шүүгч бэлтгэх сургалтыг төлбөртэй зохион байгуулна.

4.13.Сургагч-багшийн ажлын жишиг хөлс, гэрээний загвар, шүүгч бэлтгэх сургалтын төлбөрийн хэмжээ, шүүгчид багц цаг нөхөн олгох сургалтын төлбөрийн хэмжээг Сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хороогоор хэлэлцэн тогтооно.

4.14.Сургалт зохион байгуулахдаа сургалтын хөтөлбөрт нийцсэн гарын авлага, холбогдох бусад эх сурвалжаар суралцагчийг хангана.

4.15.Академи сургалтын чанарын үнэлгээг тогтмол хийж, сургалтын хөтөлбөр сайжруулах талаарх саналаа Сургалтын хөтөлбөр боловсруулах хороонд хүргүүлж болно.

4.16.Сургалтын төвд шүүгч-сургагч багшаар хууль зүйн магистр болон түүнээс дээш зэрэгтэй, шүүгчээр 5-аас доошгүй жил ажилласан эсхүл хууль зүйн сургуульд 5-аас доошгүй жил багшилсан шүүгчийг дараах журмын дагуу ажиллуулна:

4.16.1.анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нь 1 жил хүртэл хугацаагаар тус төвд шүүгч-сургагч багшаар ажиллах эрхтэй байна;

4.16.2.тухайн жилд нэг шүүхээс ажиллах шүүгч-сургагч багшийн тоо 1-ээс илүүгүй байх бөгөөд төвд жилд 5 хүртэл шүүгч-сургагч багш ажиллуулж болно;

4.16.3.шүүгч-сургагч багшаар ажиллах хүсэлтэй шүүгч нь өмнөх жилийн 12 дугаар сарын 2-ны өдрийн дотор дараах бичиг баримтыг бүрдүүлэн Сургалтын төвд ирүүлнэ:

4.16.3.1.шүүгч-сургагч багшаар ажиллах хүсэлт;

4.16.3.2.шүүгч-сургагч багшаар ажиллуулахыг дэмжсэн тухайн шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, тэмдэглэл;

4.16.3.3.шүүгч-сургагч багшаар ажиллуулахыг дэмжсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол;

4.16.3.4.сургалт заах чиглэл, мэргэшсэн байдлыг нотлох баримт;

4.16.3.5.сургагч багшаар ажиллаж байсан туршлагыг нотлох баримт.

4.16.4.шүүгч-сургагч багшаар ажиллах тохиолдолд шүүгчийн цалин хөлсийг тухайн шүүхээс хэвээр олгож, шүүгчээр ажилласанд тооцно.

4.16.5.шүүгч-сургагч багшаар ажиллах хүсэлтэй шүүгчийн холбогдох баримт бичгийг Сургалтын төвийн дарга хянаж, Шүүхийн академийн захиралд танилцуулах бөгөөд Шүүхийн академийн захирал төвийн бодлого, тухайн жилийн сургалтын

төлөвлөгөө, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын үндэслэл зэргийг харгалзан тухайн жилд шүүгч-сургагч багшаар ажиллуулах эсэхийг Улсын дээд шүүхийн танхимын тэргүүнүүдийн саналыг авч Ерөнхий шүүгчтэй зөвшилцэн шийдвэрлэнэ;

4.16.6.шүүгч-сургагч багш нь Шүүхийн академид ажиллахдаа Сургалтын төвд харьяалагдан, тус төвийн төлөвлөгөөний дагуу шүүгчийн болон шүүгч бэлтгэх сургалтад сургагч багшаар ажиллана.

4.16.7.шүүгч-сургагч багш нь гүйцэтгэлийн тайлангаа Шүүхийн академи болон тухайн шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнд тайлагнах үүрэг хүлээнэ.

#### Тав.Шүүхийн судалгааны төв

5.1.Судалгааны төв шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд шүүх, шүүгчийг судалгаа, мэдээллээр хангах, хуулийг зөв хэрэглэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад болон хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал уламжлахад шаардагдах судалгааг шинжлэх ухааны түвшинд хийж гүйцэтгэх замаар шүүх, шүүгчийг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.2.Судалгааны төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.2.1.шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн үр нөлөө болон түүнийг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийх;

5.2.2.шүүхийн хууль хэрэглээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикийг шүүн таслах ажиллагааны статистикт үндэслэн салбар эрх зүй, хэрэг, маргааны төрлөөр судлах;

5.2.3.Олон улсын эрх зүйн баримт бичиг, гадаад улсын эх сурвалжийн харьцуулсан судалгаа хийх;

5.2.4.хууль зүйн салбараас бусад шинжлэх ухааны тодорхой салбар болон салбар дундын асуудлаарх судалгааг захиалгаар хийлгэх, энэ хүрээнд бусад судалгааны байгууллага, судлаачтай хамтран ажиллах;

5.2.5.Улсын дээд шүүх, Шүүхийн академиас батлах дүрэм, журам, зааврын төслийг боловсруулахад шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангах;

5.2.6.шүүх судлал, судалгааны чанар, арга зүйг хөгжүүлэх зорилгоор бусад байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох;

5.2.7.Шүүхийн академийн болон дотоод, гадаадын судалгааны байгууллагын гаргасан судалгааны тайлан болон судалгааны баримт бичгийн цахим сан бүрдүүлэх, төвөөс эрхлэн гаргах судалгааны тайлан, бусад баримт бичгийн эх бэлтгэх, хэвлүүлэх;

5.2.8.олон нийтэд зориулсан хураангуй бэлтгэх онцлох шүүхийн шийдвэрийг тодорхойлж, хураангуйлна.

5.3.Хууль тогтоомжоор төр, байгууллага, хувь хүний нууцад хамааруулснаас бусад асуудлаарх судалгааны үр дүнг олон нийт танилцах боломжоор хангана.

5.4. Судалгааны төв нь эрүүгийн эрх зүйн сектор, иргэний эрх зүйн сектор, захиргааны эрх зүйн сектор, үндсэн хууль болон олон улсын эрх зүйн сектороос бүрдэнэ.

5.5. Төвд эдийн засаг, татвар, нягтлан бодох бүртгэл, статистик, социологийн зэрэг шаардлагатай шинжлэх ухааны салбарын судлаачдыг ажиллуулж болно.

5.6. Судалгааны төвд шүүгч-судлаачийг дараах журмын дагуу ажиллуулна:

5.6.1. анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нь 6 сар хүртэл хугацаагаар тус төвд Шүүгч-судлаачаар ажиллах эрхтэй байна;

5.6.2. тухайн жилд нэг шүүхээс ажиллах шүүгч-судлаачийн тоо 1-ээс илүүгүй байх бөгөөд төвд жилд 5 хүртэл шүүгч-судлаач ажиллуулж болно;

5.6.3. Шүүгч-судлаачаар ажиллах хүсэлтэй шүүгч нь тухайн жилийн 12 дугаар сарын 2-ны өдрийн дотор дараах бичиг баримтыг бурдуулэн Судалгааны төвд ирүүлнэ:

5.6.3.1. Шүүгч-судлаачаар ажиллах хүсэлт;

5.6.3.2. Шүүгч-судлаачаар ажиллуулахыг дэмжсэн тухайн шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, тэмдэглэл;

5.6.3.3. судалгааны ажлын ерөнхий төлөвлөгөө (судалгаа хийх хэрэгцээ шаардлага, үндэслэл, зорилго, чиглэл, хүлээж буй үр дүн, шаардлагатай хугацаа, график зэргийг тодорхой заасан байх).

5.6.4. Шүүгч-судлаачаар ажиллах тохиолдолд шүүгчийн цалин хөлсийг тухайн шүүхээс хэвээр олгож, шүүгчээр ажилласанд тооцно;

5.6.5. судлаачаар ажиллах хүсэлтэй шүүгчийн бичиг баримт, судалгааны ажлын ерөнхий төлөвлөгөөг Судалгааны төвийн дарга хянаж, Шүүхийн академийн захиралд саналаа танилцуулах бөгөөд Шүүхийн академийн захирал төвийн бодлого, тухайн жилийн ажлын төлөвлөгөө, захиалгаар судалгаа хийх бол захиалга өгч буй шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын үндэслэл зэргийг харгалзан тухайн жилд шүүгч-судлаачаар ажиллуулах эсэхийг шийдвэрлэнэ;

5.6.6. Шүүхийн академиас судалгааны үр дүн, чанар, үнэлгээний аргачлал, цагийн багтаамжийг нарийвчлан тогтоох бөгөөд шүүгч-судлаач нь гүйцэтгэлийн тайлангаа Шүүхийн академи болон тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд тайлагнах үүрэг хүлээнэ.

### Зургаа. Мэдээллийн төв

6.1. Мэдээллийн төв шүүн таслах ажиллагааг мэдээллээр хангах, шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэх, олон нийтэд мэдээлэх талаар дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:

6.1.1.энэ журмын 5.2.9-д заасны дагуу Судалгааны төвийн хураангуйлсан онцлох шүүхийн шийдвэрийн хураангуйг олон нийтэд цахим болон бусад эх сурвалжаар тогтмол мэдээлэх;

6.1.2.шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаар олон нийтэд мэдээлэх, шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах талаар мэргэжил арга зүйн зөвлөмжийг шүүхүүдийн Тамгын газарт өгөх;

6.1.3.сургалт, судалгааны чиглэлээр “Монголын төр, эрх зүй” тогтмол сэтгүүл, Шүүхийн академийн сар тутмын үйл ажиллагааны цахим сонин эрхлэн гаргах, хэвлэн нийтлэх бусад үйл ажиллагаа эрхлэх;

6.1.4.шүүхийн судалгаа, сургалтад ашиглагдах хууль зүйн ахисан түвшний ном, бүтээлийн сан бүхий номын сангийн үйл ажиллагаа эрхлэх, сан хөмрөгийг нэмэгдүүлэх, ном, бүтээлийн эх сурвалжийн лавлагаа бэлтгэж үйлчлэх;

6.1.5.Судалгааны төвийн бүрдүүлсэн шүүхийн судалгааны тайлангийн цахим сангаар шүүгч, олон нийтэд үйлчлэх;

6.1.6.шүүхийн сургалтын видео материал, цахим подкаст, ярилцлага бэлтгэх, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, шүүхийг үйл ажиллагааг мэдээлэхэд чиглэсэн мэдээ, нэвтрүүлэг бэлтгэх, түгээх студи ажиллуулах;

6.1.7.Шүүх академийн бусад төв, нэгжийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг шүүх, олон нийтэд тухай бүр таниулах, сурталчлах, мэдээлэхэд арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх.

#### Долоо.Шүүхийн академийн санхүүжилт

7.1.Шүүхийн академийн үйл ажиллагааны зардлыг Улсын дээд шүүхийн төсвөөс санхүүжүүлнэ.

7.2.Шүүхийн академийн санхүүжилтийг Улсын дээд шүүхийн жил бүрийн төсөвт тусгана.

7.3.Шүүхийн академийн үйл ажиллагааг хууль тогтоомжоор хориглоогүй төлбөрт сургалт, судалгааны орлого гадаадын зээл, тусlamжийн хөрөнгө бусад эх үүсвэрээс нэмж санхүүжүүлж болно.

#### Найм.Шүүхийн академийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

8.1.Шүүхийн академийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Улсын дээд шүүхийн танхимын саналыг авч Ерөнхий шүүгчид уламжлан шийдвэрлүүлнэ.